



**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**

ШУДАРГА НИЙГМИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА



Empowered lives.  
Resilient nations.



**BREAK THE CORRUPTION CHAIN**

## “Монгол Улсын барилгын салбар дахь авлигын нөхцөл байдал”

### 2015 оны 12 дугаар сарын 9

*Улаанбаатар.* Судалгааны дүнгээс харахад барилгын зөвшөөрөл авахаас эхлээд улсын комисс барилгыг шаардлага, стандартыг хангасан гэж үзэн хүлээн авах хүртэлх бүхий л үе шатанд барилгын компаниуд авлигын эрсдэлтэй тулгардаг байна. Авлигын зардал барилгын жижиг, том компаниудын аль алинд нь бэрхшээл учруулж, улмаар хэрэглэгчид тусах үнэ өсдөг. Тэгвэл эдгээр үе шат бүрт авлигын чухам ямар эрсдэл гардаг вэ, түүнийг яаж арилгах вэ? Энэ бол 2015 оны 11 дүгээр сарын 23-нд Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхим дээр болсон барилгын компаниуд, мэргэжлийн холбоод, Засгийн газрын холбогдох байгууллагын төлөөлөл оролцсон хэлэлцүүлгийн гол сэдэв байлаа.

Хэлэлцүүлэг өрнүүн, илэн далангүй явагдаж, авлигын ноцтой эрсдэл, үр дагаврын талаар хөндөв. **Барилгын тусгай зөвшөөрөл олгож буй эрх бүхий субъект уг зөвшөөрлийн дагуу барилга барьсан компаний нийгэмд учруулж буй аливаа хохиролд хариуцлага хүлээдэггүй. Өөрөөр хэлбэл, уг компани нь анхнаасаа тусгай зөвшөөрлийн шаардлага хангаж чадахуйц компани байсан эсэх талаар асуудал яригддаггүй. Мөн мэргэжлийн хяналтын байцаагч барилгыг хүлээн авч, гарын үсэг зурсан ч уг барилга нь шаардлага хангахгүй зүйл гарахад уг хүлээн авсан хүн хариуцлага хүлээдэггүй. Мөн сүүлийн үед аливаа зөвшөөрөл авахад мөнгө бус компанид хувьцаа эзэмших санал тавьдаг үзэгдэл гарч байна.**

АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх газрын дарга Бат-отгон хэлэхдээ “Авлига бол зөвхөн төрийн байгууллагын шийдэх асуудал гэсэн ойлголт давамгайлж байдаг. Гэтэл сүүлийн үед энэ асуудал хувийн хэвшилд ч чухал хамаатай болж ирлээ” гэв. Барилгын компанийн хөрөнгө оруулагч, эздийн зүгээс дунд шатны ажилтнууд бүтээгдэхүүнийг хямдруулж аваад, албан ёсны гэрээнд хямдралгүй үнээр тусгадаг байдал нэлээд түгээмэл гардаг тухай яриу.

Эцэст нь, барилгын компаниуд барилгын салбартай холбоотой аливаа дүрэм, журам, стандарт боловсруулахдаа тэднийг оролцуулж байх нь чухал гэдгийг онцлон тэмдэглэв. Цаашид бизнесийн салбарынханд авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниуцлах, мөн авлигын эрсдлийг

арилгах чиглэлээр тогтвортой хамтын ажиллагаа чухал болохыг талууд онцолж, хамтын ажиллагааг өрнүүлэх чиглэлээр хүчин чармайлт гарган ажиллахад цаашид анхаарахаар ярилцжээ.

*Энэхүү хэлэлцүүлгийг 2015 оны Олон улсын Авлигын эсрэг өдрийг угтан Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхим, Авлигатай тэмцэх газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран зохион байгуулсан болно.*